

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/30/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	21
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	21
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Төв аймаг, Зууныд-688
т.х. 76272582 Цахим хуудал: gov.mn
Цахим хуудал: gov.mn/audit.mn

2023.02.20 № 01/64
Танар _____ Үнэг № _____

ТӨВ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 338 байгууллагын 324.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг улсын үзлэг тооллогод бүрэн хамруулан тоолж, нэгтгэлийн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсөв санхүү, эдийн засаг, хөгжлийн хороо, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 13 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт нэгтгүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, 1-2 өрөө 36 айлын түрээсийн орон сууцтай болсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцсөний дагуу Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хуучин дулааны станцын барилга

байгууламж, тоног төхөөрөмжийг хувьчилж худалдахаар 3 дахь нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж, худалдах доод үнэ 1,647,990.0 мянган төгрөгөөс 2,011,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж зарсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/125 тоот захирамжаар уг дуудлага худалдааг бүх нийтийн амралтын өдөр зохион байгуулсан гэх үндэслэлээр хүчингүй болгосон байна.

Түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг бүртгэх бүртгэлийн орчин, эрх зүйн үндэслэл бүрдээгүйгээс 2022 оны авлага өглөгийн тооцосг үүсгээгүй, төлөлтийг бүртгээгүй, авлагын эхний, эцсийн үлдэгдэл 118,354.9 мянган төгрөгөөр өөрчлөлтгүйгээр тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,044,788,616.46	1,045,272,316.46
33	АВЛАГА	118,354,888.46	118,354,888.46
335	Бусад авлага	118,354,888.46	118,354,888.46
35	БАРАА МАТЕРИАЛ	926,433,728.00	926,917,428.00
351	Түүхий эд материал	88,800.00	88,800.00
35130	Эм боох материал	88,800.00	88,800.00
354	Хангамжийн материал	926,344,928.00	926,828,628.00
35410	Бичиг хэргийн материал	300,000.00	742,500.00
35420	Аж ахуйн материал	3,651,179.00	3,678,279.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,160,000.00	1,160,000.00
35450	Барилгын засварын материал	74,800.00	88,900.00
35470	Бусад хангамжийн материал	921,158,949.00	921,158,949.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	825,387,353.92	808,047,987.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	825,387,353.92	808,047,987.20
392	Биет хөрөнгө	804,447,020.64	785,560,320.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	777,147,193.00	777,147,193.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,032,993.06	-53,361,699.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,985,000.00	88,985,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,444,895.55	-44,001,353.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,167,094.00	23,802,129.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,774,257.03	-8,750,973.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,274,303.20	12,274,303.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,874,423.92	-10,534,278.60
393	Биет бус хөрөнгө	20,940,333.28	22,487,666.56
39301	Програм хангамж	308,000.00	308,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-102,666.72	-205,333.44
39303	Бусад биет бус хөрөнгө	20,735,000.00	22,385,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,870,175,970.38	1,853,320,303.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	118,124,380.35	119,042,370.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	118,124,380.35	119,042,370.47
413	Өглөг	118,124,380.35	119,042,370.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	112,418.21
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	118,124,380.35	118,929,952.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,752,051,590.03	1,734,277,933.19
51	Засгийн газрын хувь оролцоо	1,752,051,590.03	1,734,277,933.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,735,000.00	20,735,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,683,583,285.83	1,665,809,628.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,702,898,655.96	1,683,583,285.83
51220	Тайланг үеийн үр дүн	-19,315,370.13	-17,773,656.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,733,304.20	47,733,304.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,870,175,970.38	1,853,320,303.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	238,204,600.00	274,935,235.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,000.00	9,861,635.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,000.00	9,861,635.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,000.00	9,766,635.00
120009	Бусад орлого	00.00	95,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,154,600.00	265,073,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,865,500.00	8,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,865,500.00	8,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	230,289,100.00	256,953,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	230,289,100.00	256,953,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	257,469,970.13	288,884,291.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	257,469,970.13	288,884,291.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,238,231.38	288,514,482.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,582,767.00	134,048,000.00
210101	Үндсэн цалин	122,479,116.00	98,771,945.06
210102	Нэмэгдэл	25,550,951.00	27,026,037.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,552,700.00	3,564,798.40
210104	Урамшуулал	00.00	4,685,218.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,270,720.67	16,748,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,626,538.67	11,513,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,458,774.08	1,308,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,156,579.29	1,047,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,184.39	261,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,753,644.24	2,617,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,572,388.90	30,743,996.91
210301	Гэрэл, цахилгаан	5,459,281.00	5,502,642.41
210302	Түлш, халаалт	24,183,168.90	24,678,539.50
210303	Цэвэр, бохир ус	929,939.00	562,815.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,545,200.00	13,399,340.97
210401	Бичиг хэрэг	1,852,500.00	2,341,820.00
210402	Тээвэр, шатахуун	6,085,200.00	7,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,607,500.00	3,107,520.97
2105	Нормативт зардал	85,400.00	242,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	85,400.00	242,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,631,440.00	00.00
210604	Урсгал засвар	3,631,440.00	00.00
2107	Томилуулт, зочны зардал	6,677,100.00	10,195,500.00
210702	Дотоод албан томилолт	6,677,100.00	10,195,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	934,440.00	47,387,718.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	46,951,618.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	136,700.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,740.00	216,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	198,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,938,774.81	35,748,976.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,715,600.00	9,811,375.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	617,500.00	313,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,605,674.81	25,624,401.72

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,231,738.75	369,809.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,231,738.75	369,809.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,586,738.75	369,809.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-19,265,370.13</u>	<u>-13,949,056.84</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,000.00	3,824,600.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	50,000.00	3,824,600.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-50,000.00	-3,824,600.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-19,315,370.13</u>	<u>-17,773,656.84</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	238,154,600.00	265,168,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	95,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	95,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	95,000.00
120009	Бусад орлого	00.00	95,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,154,600.00	265,073,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,865,500.00	8,120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,865,500.00	8,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	230,289,100.00	256,953,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	230,289,100.00	256,953,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	234,649,700.00	262,825,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,649,700.00	262,825,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,417,961.25	262,455,790.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,717,238.00	133,988,000.00
210101	Үндсэн цалин	122,613,587.00	98,711,945.46
210102	Нэмэгдэл	25,550,951.00	27,026,037.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,552,700.00	3,564,798.00
210104	Урамшуулал	00.00	4,685,218.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,291,154.35	16,748,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,196,781.33	11,513,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,579,927.19	1,308,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,253,501.78	1,047,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	296,285.79	261,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,964,658.26	2,617,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,572,388.90	30,272,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,459,281.00	5,031,545.50
210302	Түлш, халаалт	24,183,168.90	24,678,539.50
210303	Цэвэр, бохир ус	929,939.00	562,815.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,354,200.00	13,855,040.97
210401	Бичиг хэрэг	1,962,500.00	2,848,420.00
210402	Тээвэр, шатахуун	4,784,200.00	7,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,607,500.00	3,056,620.97
2105	Нормативт зардал	583,300.00	269,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	583,300.00	269,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,866,240.00	00.00
210604	Урсгал засвар	4,866,240.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	6,765,900.00	10,195,500.00
210702	Дотоод албан томилолт	6,765,900.00	10,195,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	934,440.00	47,412,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	46,679,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	136,700.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,740.00	216,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	495,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,333,100.00	9,714,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,715,600.00	9,485,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	617,500.00	229,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,231,738.75	369,809.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,231,738.75	369,809.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,586,738.75	369,809.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,504,900.00	2,343,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,504,900.00	2,343,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,504,900.00	2,343,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,504,900.00	2,343,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,504,900.00	2,343,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,504,900.00	-2,343,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,702,898,655.96	00.00	1,771,366,960.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,702,898,655.96	00.00	1,771,366,960.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-19,315,370.13	00.00	-19,315,370.13
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	00.00	1,752,051,590.03
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	00.00	1,752,051,590.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,683,583,285.83	00.00	1,870,175,970.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-17,773,656.84	00.00	-17,773,656.84
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,735,000.00	47,733,304.20	1,665,809,628.99	00.00	1,734,277,933.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	256,953,600.00	256,690,790.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	256,953,600.00	256,690,790.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,953,600.00	256,690,790.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,988,000.00	133,988,000.00
210101	Үндсэн цалин	95,535,600.00	98,711,945.46
210102	Нэмэгдэл	33,652,400.00	27,026,037.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,800,000.00	3,564,798.00
210104	Урамшуулал	0	4,685,218.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,748,400.00	16,748,400.00
210201	Тэтгэврийн даатгал	11,513,300.00	11,513,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,308,800.00	1,308,800.00
210203	ҮОМШҮ-ний даатгал	1,047,000.00	1,047,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	261,800.00	261,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,617,500.00	2,617,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,272,900.00	30,272,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,900,000.00	5,031,545.50
210302	Түлш, халаалт	22,872,900.00	24,678,539.50
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	562,815.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,906,200.00	13,855,040.97
210401	Бичиг хэрэг	2,802,400.00	2,848,420.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,603,800.00	3,056,620.97
2105	Нормативт зардал	282,200.00	269,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	282,200.00	269,650.00
2107	Томилолт, зочны зардал	10,200,000.00	10,195,500.00
210702	Дотоод албан томилолт	10,200,000.00	10,195,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,505,900.00	47,412,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,679,200.00	46,679,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,700.00	216,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	580,000.00	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,050,000.00	3,949,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	449,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	256,953,600.00	256,690,796.97
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	256,953,600.00	256,690,796.97
320001	Орон нутгийн төсвөөс	256,953,600.00	256,690,796.97
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,220,500.00	8,108,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,220,500.00	8,108,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,220,500.00	8,108,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,220,500.00	8,108,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,220,500.00	8,108,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,220,500.00	8,108,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,220,500.00	8,108,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,220,500.00	8,108,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан холбогдох чиг үүргийг орон нутагт хариуцан гүйцэтгэж аймгийн ИТХ, Засаг даргад эрхлэх асуудлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх төсвийн хөрөнгө болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж худалдан авах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж, орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулж, бүрэн бүтэн байдал, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил, тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан шилэн тендер зохион байгуулах.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 48 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 94.3%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний А/01 тоот захирамж, Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/03 дугаарын тушаалаар: дарга 1, худалдан авах ажиллагааны алба 5, өмчийн мэргэжилтэн 3, бусад ажилтнууд 4, гэрээт жижүүр 4, нийт 17 орон тоотой байхаар бүтэц орон тоог баталж үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын 2 удаагийн цахим сургалт хийж, нэгдсэн сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 04-10 өдрийн хооронд ТӨБЗГ-т зохион байгуулж, аймгийн нэгдсэн сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 26-нд ТӨБЗГ газартай хамтран зохион байгуулж, нийт 500 гаруй албан хаагчийг хамруулсан байна.

Тус газрын даргын баталсан удирдамжаар 2 ажлын хэсэг байгуулагдан 27 сумдад орон нутгийн өмчийн бүртгэл хяналт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, Улсын үзлэг тооллогын бэлтгэл ажлыг хангах хүрээнд зөрчил дутагдлыг газар дээр арилгуулан хугацаатай үүрэг даалгавар өгч, зөвлөн туслаж ажилласан байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж 2022 онд 1,600,000.0 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тэг төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчилэн тогтоосон байна.

Холбогдох хууль журмын дагуу барилга, тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг нээлттэй зарлан, зохион байгуулж, аймгийн төсвийн орлогод 255,700.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна..

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь байгууллагын даргын тушаалаар 2016 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа боловч түрээсийн орон сууцны орлогыг бүртгэх бүртгэлийн орчин, эрх зүйн үндсийг бүрдүүлж шинэчлэх шаардлагатай болсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,855.7 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	118,354.9	118,354.9	0.0
Бараа материал	926,433.7	926,917.4	483.7
Үндсэн хөрөнгө	825,387.4	808,048.0	-17,339.4
Нийт хөрөнгө	1,870,176.0	1,853,320.3	-16,855.7
Өр төлбөр	118,124.4	119,042.4	918.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,752,051.6	1,734,277.9	-17,773.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,870,176.0	1,853,320.3	-16,855.7

Дээрх хүснэгтээс харахад: Түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг бүртгэх бүртгэлийн орчин, эрх зүйн үндэслэл бүрдээгүйгээс 2022 оны авлага, өглөгийн тооцоог үүсгээгүй, төлөлтийг бүртгээгүй, авлагын дансны эхний, эцсийн үлдэгдэл 118,354.9 мянган төгрөгөөр өөрчлөлтгүйгээр тайлагнасан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 926,433.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 2,343.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 22-ны А/159 захирамжаар улсын үзлэг тооллогын ажилд зориулан нөөц сангаас 3,824.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй бэлтгэн нийлүүлж, 20,377.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар оны эцсийн үлдэгдэл 926,917.4 мянган төгрөг (үүнээс 913,397.3 мянган төгрөг нь түрээсийн орон сууц) болж 483.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 825,387.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 2,343.0 мянган төгрөгийн вэб сайт, хард худалдан авч, аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 22-ны А/159 захирамжаар улсын үзлэг тооллогын ажилд зориулан 3,600.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, өнгөт принтер, ТӨБЗГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны Б/106 тушаалаар 2,342.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер үнэ төлбөргүй шилжүүлэн авч оны эцсийн үлдэгдэл 924,901.6 мянган төгрөг болж тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан үлдэгдэл өртөг 17,339.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 118,124.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 119,042.4 мянган төгрөг болж, 918.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүний орлогын албан татварын өглөг, гэрэл цахилгааны тооцоо нэмэгдэж үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,734,277.9 мянган төгрөг болж 17,773.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 247,953.9 мянган төгрөг, нийт зарлагыг 247,953.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 9,000.3 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 238,953.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 24-ний 03 тоот тогтоолоор 18,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 256,953.6 мянган төгрөгөөр баталж, төсөвт 1 удаа тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 238,953.6 мянган төгрөгийг 18,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 256,953.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 369.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 256,321.0 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 12,726.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 53.6 мянган төгрөг, нийт 12,779.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	210,274.4	209,904.6	369.8	99.8%
2	70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	46,679.2	46,679.2	0	100%
	70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн дүн	256,953.6	256,583.8	369.8	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансаар цахим тендерийн хураамж, дуудлага худалдаа зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 8,108.0 мянган төгрөгийн орлого, зардлын гүйлгээ гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн өмнөх оны гүйцэтгэлтэй зэрэгцүүлсэн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70426-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	2022.01.01-2022.12.31	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөр 99.8 %	256,953.6	256,583.8

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх /70426/ хөтөлбөрийн зардлыг 99.8 хувь буюу 0.2 % хувиар дутуу зарцуулж орон нутгийн орлогод татан төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 48 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 256,953.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,854.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,890.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт илтгэх хуудсаар хавсаргаж ирүүлсэн. Тус байгууллагын 2022 онд шаардлагатай гэж төсөвлөсөн 238,953.6 мянган төгрөгийг 18,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна.

Орон нутгийн өмчийн газрын нэг төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөр, 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 256,953.6 мянган төгрөгийн төсөв батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 369.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 12 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад, 1 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 322 дугаар тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	0	1	0	100
Зөвлөмж	1	5,039.9	1	5,039.9	100
Нийт дүн	2	5,039.9	2	5,039.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал нь түрээсийн орон сууцны тооллого, тооцоо, эзэмшлийн асуудлыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан хөрөнгийн зардлын 2.343.0 мянган төгрөгөөр, Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 369.8 мянган төгрөгөөр тус тус тохируулга хийгээгүйгээс нийт 2,712.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийлээ.

Аудитаар нийт 1,442.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 182.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,260.5 мянган төгрөгийн 4 зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож олгосон 182.4 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1.Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлаас бэлтгэсэн 7,950.0 мянган төгрөгийн шатахууныг орлого авсан дүнгээр шууд зардалд бичиж бүртгэсэн бөгөөд 1,030.0 мянган төгрөгийн шатахууны тооцоог жишиг нормыг баримталж бодолт хийгээгүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 4-д "Жолоочийн тооцооны хуудас", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шатахууны жишиг нормыг баримтлан сар бүр тооцоог бодох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. *Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал*

2.1.Илрүүлэлт:

Түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг 2022 оны авлага өглөгийн тооцоог үүсгээгүй, төлөлтийг бүртгээгүй, авлагын эхний, эцсийн үлдэгдлийг 118,354.9 мянган төгрөгөөр өөрчлөлтгүйгээр тайлагнасан байна. Байгууллагаас авах авлагаар тайлагнасан 230.5 мянган төгрөгийн авлага нь бараа материалын өглөг, ажиллагчидтай холбогдсон өглөг тооцооны дансанд зөрүүлж илэрхийлсэн зөрчлүүд байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "ангилал", "тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, түрээсийн орлогыг бүртгэх бүртгэлийн орчин, эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх.

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Ажилтнуудын ажлын цагийн бүртгэл байхгүй, цалинг олгож байгаа зөрчил байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цагийн бүртгэлийг баримтлан цагийн тооцоог гаргаж, цалинг олгон зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт:

Бусад хангамжийн материалд бүртгэлтэй түрээсийн орон сууцны тооллогын бүртгэл үйлдэгдээгүй, орон сууц эзэмшигч нартай хийсэн гэрээний дагуу илтгэх хуудас бичиж, үр дүнг тооцоо бодсон актаар албажуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэж заасантай тус тус нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "тасалбар болголт", "нийцсэн бөгөөд зохистой байх", "оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай хийж хэвших, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул-сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлын 2.343.0 мянган төгрөгөөр, Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 369.8 мянган төгрөгөөр тус тус тохируулга хийгээгүй алдаатай тайлагнасан байна.	1	2,712.8			1	2,712.8	1	2,712.8				
Дүн	1	2,712.8	0	0.0	1	2,712.8	1	2,712.8	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн										
Албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож олгосон.	1	182.4	1	182.4								
Тээвэр шатахууны зардлаас бэлтгэсэн 7,950.0 мянган төгрөгийн шатахууныг орлого авсан дүнгээр шууд зардалд бичиж бүртгэсэн бөгөөд 1,030.0 мянган төгрөгийн шатахууны тооцрог жишиг нормыг баримталж бодолт хийгээгүй зөрчил байна.	1	1,030.0					1	1,030.0				
Түрээсийн орон сууцны түрээсийн орлогыг 2022 оны авлага өглөгийн тооцрог үүсгээгүй, төлөлтийг бүртгээгүй, авлагын эхний, эцсийн үлдэгдэлийг 118,354.9 мянган төгрөгөөр өөрчлөлтгүйгээр тайлагнасан байна. Байгууллагаас авах авлагаар тайлагнасан 230.5 мянган төгрөгийн авлага нь бараа материалын өглөг, ажиллагчидтай холбогдсон өглөг тооцооны дансанд зөрүүлж илэрхийлэгдсэн зөрчлүүд байна.	1	230.5					1	230.5				
Төв аймгийн засаг даргын 2022 оны 1 дүгээр сарын 04-ний А/01 тоот захирамж, Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/03 дугаарын тушаалаар 17 орон тоотой байхаар бүтэц орон тоог баталсан байна. Энэ ажилтнуудын ажлын цагийн бүртгэл байхгүй цалинг олгож байгаа зөрчил байна.	1	0.0					1	-				
Бараа материалыг дэлгэрэнгүй бүртгэлээс түүвэрлэн жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад 913,397.3 мянган төгрөгийн түрээсийн орон сууц тооллогын бүртгэл үйлдэгдээгүй, Түрээсийн гэрээ байгуулсан гэх боловч тооллогын бүртгэл, илтгэх хуудсаар тодруулж, үр дүнг тооцоо бодож албажуулан санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил байна.	1	0.0					1	-				
Дүн	5	1,442.9	1	182.4	0	0.0	4	1,260.5	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0